



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/38

Шивээговь сум

Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.4.1, 58.4.11, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/243 дугаар тушаал “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам”-ын 6.7, 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Суманд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах комиссын хурлын шийдвэрээр дэмжигдсэн төсөлд зээл олгосугай.


2.Дэмжигдсэн төслийг хавсралтаар баталсугай.

3.Дэмжигдсэн төслийг санхүүжүүлэх 50,000,000 (тавин сая) төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган олгохыг Нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй

4.Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан аж ахуйн нэгж, хоршоодын төслийн хэрэгжилт, зээлийн эргэн төлөлт, зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Эрдэнэтулга), (Хоршоо хөгжүүлэх сангийн хяналт тавих зөвлөл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Самуун* П.ГАНЧИМЭГ





Сумын Засаг даргын 2023 оны
03 сарын 29 өдрийн 1138 тоот
Захирамжийн хавсралт

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХОРООНЫ ХУРЛААР БАТЛАГДСАН
ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгж, иргэнийн нэр	Захирал, даргын овог нэр	РДугаар	Төслийн үйл ажиллагааны чиглэл	Хүссэн санхүүжилт
1	"Дэвжихтаван эрдэнэ"	В.Оюундэлгэр	4612906	Хадлангийн тоног төхөөрөмж худалдан авах	50,000,000
	Нийт дүн				50,000,000

Төслийн жагсаалт гаргасан:

Д.Эрдэнэтулга